



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар

Б/92

Ховд

Г.Бадамцэцэгт ажил хавсран
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь заалт, 109 дүгээр зүйлийн 109.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бичиг хэргийн оператор Батсүхийн Хишигзаяа нь хүүхэд асрах чөлөөний хугацаагаа хойшлуулсан тул ажлын зайлшгүй шаардлагаар Бичиг хэргийн оператор Ганбатын Бадамцэцэгийг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажил хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Бичиг хэргийн оператор Г.Бадамцэцэгийн нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.САНДАГСҮРЭН

